

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234702

Б.ДЭМЧИГДОРЖ МОНГОЛ ХЭЛ СУДЛААЧ БОЛОХ НЬ

Ж.Бат-Ирээдүй

Түлхүүр үг: монгол хэл, үгийн сан судлал, судлаач, авиа дуурайх үг, хэллэг

Монгол хэл шинжлэлийн түүхэнд монгол хэлийг судалж байсан олон хүмүүс байдаг боловч зарим хүн нь олны тэр бүр сайн мэддэггүй хүмүүс байх тохиолдол бий. Үүний нэг нь нэг мянга есөн зуун жар далаад онд Монгол Улсын Боловсролын яаманд монгол хэлний асуудлыг хариуцаж ажиллахын зэрэгцээ орчин цагийн монгол хэлний судалгаа хийж байсан Балжиртүндэвийн Дэмчигдорж гэж хүн юм. Энэ хүний амьдрал, судалгаа шинжилгээний ажилтай холбоотой өв, баримт материал саяхан хүрээлэнгийн сан хөмрөгт бүртгэгдсэн бөгөөд тэрхүү материалд түшиглэж энэ хүний монгол хэлний талаар хийж байсан судалгааг тодруулах, мэдээллэх зорилгоор энэхүү өгүүллийг бичиж байна.

Энэхүү тойм өгүүлэлд бидний сайн мэддэггүй нэгэн монгол хэл бичиг судлаачийн тухай өгүүлэх бөгөөд монгол хэл бичиг түүний дотор монгол хэлний зүй, монгол бичиг, монгол хэл утга зохиолын заах арга, гадаад хэлний талаар чамгүй судалгаа хийж, Монгол Улсын тухайн үеийн Гэгээрлийн Яаманд монгол хэл бичгийн асуудлыг хариуцаж байсан Балжиртүндэвийн Дэмчигдорж гэдэг хүний монгол хэл бичгийн чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээний ажил, бүтээлийн тухай товч өгүүлэх юм.

Намрын нэгэн сайхан нартай өдөр Монгол төрийн Чингис хаан одонт Гомбожавын Мэнд-Ооёо гуай утасдаж чам руу Соёлын гавьяат Д.Мягмарсүрэн аавынхаа материалыг үзүүлэхээр утас цохино гэж хэллээ. Үүнээс төд удалгүй нэг хүн ярьсан нь миний ярих гэж байгаа Дэмчигдорж гуайн ууган хүү миний мэддэг урлаг судлаач, радиогийн Мягмарсүрэн гуай байсан бөгөөд намайг гэртээ урьж аавынхаа бичсэн монгол хэл бичигтэй холбоо бүхий материалуудыг үзүүлж танай хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалуулмаар байна гэсэн санал тавьсан юм. Ингээд 2023 оны 06 дугаар сарын 06-нд бид Балжиртүндэвийн Дэмчигдорж гэж хүний 7-8 хавтас материалыг хүрээлэнгийнхээ эх хэл бичгийн сан хөмрөгийн салбарт албан ёсоор хүлээн авснаас хойш түүний тухай материалуудыг уудлан үзэж, ямар чиглэлээр юу судалж бичиж байсан талаар тодорхой баримжаатай болов. Ийнхүү монгол хэл бичгийн төлөө хөдөлмөрлөж, бүтээл туурвил хийж, тэр байтугай хоёр ч сэдвээр диссертац бичсэн боловч эрдмийн зэрэг хамгаалаагүй, ажил амьдралын маш сонин түүхтэй, бидний нэрийг нь сонссон боловч нарийн

сайн мэдэхгүй сэхээтний тухай товч боловч бичих нь зүйтэй юм хэмээн үзэж үүнийг бичиж байна.

Дэмчигдорж гэдэг нэр бол хэл шинжлэлийнхний хувьд өмнө сонсогдож, үзэгдэж харагдсан л нэр. Харин бид тэр бүр лавлаж анзаардаггүй байж. Учир нь тэр бээр алдарт Шадавын Лувсанвандан багштай хамтран 1951 онд “Монгол хэлний зүй” хэмээх бүтээлийг Улаанбаатар хотноо хэвлүүлсэн бөгөөд бид сүүлд 2010 онд Лу багшийн мэндэлсний 100 жилийн ойгоор тус номыг дахин хэвлүүлж тэр байтугай миний бие хянан тохиолдуулж байлаа.

Балжиртүндэвийн Дэмчигдорж 1923 оны 12 дугаар сарын 31-нд Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын нутаг “Ширдэгт” хэмээх газарт төрж найман нас хүртлээ эхийн гар дээр хүмүүжжээ. Ес, арван насандаа Арвайн хийдэд 2 жил Данзан гавжид шавилан сууж монгол төвөд бичиг ном заалгажээ.

1934 онд 11 насандаа Арвай хээрийн төвийн танхимд орж суралцаад 1937 онд төгсөж, 1937-41 онд Буриад Монголын нийслэл Улаан Үд хотноо байсан Монгорабфак сургуульд суралцаж байтал уг сургууль Монголын багшийн сургуультай нийлсэн тул уг сургуульд шилжин сурч, “Монгол хэл бичгийн мэргэжилтэй болж 1942 онд төгсжээ.

1942-43 онд Өвөрхангай аймгийн төвийн арван жилийн дунд сургуульд, 1943-45 онд Улаанбаатар хот дахь Мал эмнэлгийн техникумд, 1945-48 онд Улаанбаатар хотын Чойбалсангийн нэрэмжит нэгдүгээр арван жилийн дунд сургуульд тус тус багшилжээ.

Тэр бээр 1948 оны 08 дугаар сараас 1950 оны 06 дугаар сар хүртэл Ардын Гэгээрлийн Яаманд хэл бичгийн мэргэжилтнээр, 1950 оноос 1983 он хүртэл Гадаад Харилцааны Яаманд дипломат албанд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарчээ.

Энэ хугацаанд 1952 оны 08 дугаар сараас 1953 оны 07 дугаар сар хүртэл Улаанбаатар хотын намын хорооны дэргэдэх Марксизм-ленинизмын оройн университетийн проректороор томилогдон ажиллажээ. Энэ үеэс мөн Гэгээрлийн яамны мэдэлд шилжиж тус яамны заах аргын хэлтсийн хэл бичгийн мэргэжилтнээр томилогдон ажиллаж байгаад 1954 онд ЗХУ-д Сурган хүмүүжүүлэх ухааны дээд сургуульд явсан боловч 1957 оны 06 дугаар сард өвчний учир эргэн ирж МУИС-д сурган хүмүүжүүлэх ухаанаар багшлахын зэрэгцээ орос хэл утга зохиолын 4 дүгээр курст сурч 1958 оны 07 дугаар сард орос хэл бичгийн багш мэргэжлээр төгссөн байна.

Ингээд их сургууль төгсүүт Гадаад явдлын яамны канцелярийн орлогч даргаар томилогдон ажиллаж байгаад 1958 оны 10 дугаар сард БНАСАУ-д суугаа Монгол Улсын элчин сайдын яамны 3-р нарийн бичгийн даргаар томилогдоод 1960 оны 12 дугаар сард буцаж ирж Гадаад явдлын яамны сайдын дэргэдэх шалгах группийн ахлагчаар томилогджээ. 1962 оны 01 дүгээр сараас шалгах группийн ахлагчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдөж Гадаад явдлын яамны 3 дугаар хэлтсийн орлогч даргаар томилогджээ. 1962 оны 09 дүгээр сараас Гадаад явдлын яамны 3-р хэлтсийн орлогч даргаас чөлөөлж намын дээд сургуульд орос хэлний багшаар томилжээ.

Гэвч 1962 оны 11 дүгээр сараас МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний шийдвэрээр Гадаад явдлын яамны мэдэлд буцаан шилжүүлж тус яамны хэвлэлийн хэлтсийн орлогч даргаар томилогджээ. Ингээд 1963 оны 06 сараас БНАСАУ дахь Монгол Улсын элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн даргаар томилогдож ажиллаад 1966 оны 09 дүгээр сард буцаж ирэн ГЯЯ-ны 3 дугаар хэлтсийн орлогч эрхлэгчээр томилогдож 1968 он хүртэл ажиллаад Ерөнхий нарийн бичгийн газрын коллег, мэдээлэл хариуцсан референтээр томилогдон 1969 он хүртэл ажиллаж байгаад мөн оноос Улаанбаатар хот дахь ХБНСЮУ-ын Элчин сайдын яаманд орчуулагчаар томилогдож ажиллажээ.

Б.Дэмчигдорж гуайн тухай сайн мэдэх хүн ховор ч Монгол Улсын Гадаад харилцааны яамны сайд бөлгөө, Ц.Гомбосүрэн, Монгол Улсын Чингис хаан одонт Г.Мэнд-Ооёо, нэрт орчуулагч, гүүш Гэндэндарам, Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн Т.Төмөрхүлэг нарын хүмүүс саяхан зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал дээр дурсамжаа ярьж байлаа.

Тухайлбал Т.Төмөрхүлэг гуай саяхан хэвлүүлсэн “А.П.Чехов, Ёгт өгүүллэгүүд” бүтээлийн өмнөх үгт бичихдээ “Балжиртүндэвийн Дэмчигдорж гэдэг хүнтэй Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийг төгсгөж ирээд Гадаад Харилцааны Яаманд анх ажилд томилогдсон 1970 онд танилцсанаа би тодхон санаж байна. Их даруухан, үг дуу цөөтэй, нягт нямбай, нөр их хөдөлмөрч түүнийг залуу ажилтнуудад тун түшигтэй хүн гэж манай яамныхан ярьдаг сан. Юу гэвэл, Б.Дэмчигдорж гуай орос, монгол хэлд гаргууд сайн, үг найруулах, үйл явдлын утга санааг гаргах эрдэмд чамгүй мэргэшсэний тул албан баримт бичиг боловсруулах зэрэгт залуучуудад сэтгэл харамгүй тусалж зөвлөдөг хүн байжээ.” (Б.Дэмчигдорж, 2023:5) хэмээн дурсан бичжээ.

Ийнхүү Б.Дэмчигдорж Гэгээрлийн яаманд хоёр удаа, Гадаад явдлын яаманд мөн хоёр удаа өндөр насны тэтгэвэрт гартлаа ажилласан ба энэ хугацаанд монгол хэл бичгийн талаар чармайн ажиллаж хэд хэдэн бүтээл хэвлүүлж, нэлээд тооны эрдэм шинжилгээний өгүүлэл, мөн заах арга, сурталчилгааны өгүүллийг төвийн сонин хэвлэлүүдэд нийтлүүлж байжээ.

Тухайлбал, монгол хэл, бичиг үсгийн чиглэлийн ном сурах бичгийн хувьд “Хэл яриа яаж бий болов” (1948), “Бичиг үсэг бага мэдэгчдийн уншихад тусламж”, Шадавын Лувсанванданы хамт “Монгол хэлний зүй” (1951), “Хуучин монгол бичгийн товч сурах бичиг” (1952), “Хэл бичиг заах аргын гарын авлага” (1955), “Бичиг үсэг бага мэдэгчдийн уншихад тусламж 1” зэрэг ном бүтээлийг хэвлүүлсэн бол эрдэм шинжилгээ, заах аргын чиглэлээр “Бага сургуулийн уншлагын арга” (1954), “Асуух уу, үү, юу, юү, бэ, вэ үгнүүдийг хэрхэн хаана хэрэглэх тухай” (????), “Бага ангийн сурагчдыг зөв уншлагад хэрхэн сургах вэ?” (1950), “Сургуулиудад уйгаржин (хуучин) бичгийн заалтыг сайжруулъя” (1952), “Хуучин бичгийг орхиж болохгүй” (1952), “Монгол хэлний зүйг 5-7 дугаар ангид заах аргын үндсэн тойм” (1953), “Утга зохиолын уншлагын хичээлийг хэрхэн зохион байгуулж, яаж явуулах тухай заах арга” (1953), “Уран тод уншилтад сургахуй нь” (1954), “Манай сургуулиудын амьдралын гол асуудал бол заах арга, сурган хүмүүжүүлэх мөн” (1954), “Хичээлээс гадуур явуулах уншлагын тухай” (1954), зэрэг өгүүлэл бичиж тухайн үеийн “Багш”, “Сурган хүмүүжүүлэгч”, “Цог”, “Пионер” зэрэг тогтмол хэвлэл, сонин, сэтгүүлүүдэд хэвлүүлж байжээ.

Хэл бичиг, хэл соёл, утга зохиолыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр “Ленин Сталин нар орос хэлний тухай” (1953, Үнэн), “Хэл бичиг, утга зохиолын хичээлийг сурагчдын үзэл суртал ба хүмүүжил боловсролтой хэрхэн холбох вэ?” (1949), “Чойбалсан ба Монголын утга зохиол” (1952), “Сургуулиудад утга зохиолын уншлагын хичээлийн заах арга дээр анхаарлаа сайн тавигтун” (1953), “Багш бүхэн дунд ба бага сургуулийн багш гэдэг цол авахын тул биеэ сайн бэлтгэе” (Үнэн, 1953), “И.В.Сталины Марксизм ба хэлний шинжлэлийн асуудлууд гэдэг зохиолын нийтлэгдсэний 3 жилийн ойд”, “Оросын их хувьсгалч ардчилсан үзэлтэн философи-материалист нийтлэгч бөгөөд зохиолч А.И.Герцен (1812-1870), “Л.Н.Толстойн төрсөн өдрийн 125 жилийн ойд сургуулиуд хэрхэн бэлдэж өнгөрүүлэх тухай товч төлөвлөгөө”, “Сайхан шинэ бүтээл (Монгол орос толийн тухай)” зэрэг олон өгүүлэл, тайлбар өгүүлэл нийтлүүлжээ.

Эдгээр бүтээлүүдээс бид бүхний сайн мэдэх Шадавын Лувсанвандан багштай хамтарч бичин 1951 онд хэвлүүлсэн “Монгол хэлний зүй” бүтээлийн нэгдүгээр дэвтэр нь хэдийгээр “Авиа ба үгийн зүй” 7 жилийн ба дунд сургуулийн 5, 6 дугаар ангиудад үзнэ, редактор Я.Цэвэл, Гэгээрлийн Яамны коллегийн хурлаар батлав, улсын хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 1951 гэх боловч үнэн хэрэгтээ энэ ном нь өгүүлбэр судлалын ном юм. Энэ номд монгол хэлний үг холбох ёс, өгүүлбэрийн бүрэлдэхүүн, энгийн өгүүлбэрийн тухай гол гишүүд ба тэдгээрийг илрүүлэх нь, туслах гишүүд ба тэдгээрийг илрүүлэх нь, хандсан үгийн учир, аялгуу өгүүлбэрийн тухай, аялгуу өгүүлбэрийн тухай, нийлмэл өгүүлбэрийн тухай, хөндлөнгийн үг гэсэн асуудлуудыг авч үзсэн байдаг. Уг номын оршилд Ш.Лувсанвандан, Б.Дэмчигдорж нар бичихдээ “Хэл бол сэтгэхтэй шууд холбоотой байдаг тул үгэнд мөн үгнүүдийн холбоо, өгүүлбэрт сэтгэхийн ажиллагааны үр дүн, сэнхрэн мэдрэх ажлын амжилтыг бүртгэж бататгаад тийнхүү хүний нийгэмд санал солилцох бололцоотой болгодог юм. Санал солилцох явдал бол байнгын бөгөөд амьдралын чухал зүйл мөн. Учир нь үүнгүйгээр аж төрөхийн зайлшгүй хэрэгцээт зүйлийг бүтээн үйлдвэрлэхийн төлөө, байгалийн хүчинтэй тэмцэхэд хүмүүсийн хамтарсан ажиллагааг эмхлэн зохиож болохгүй. Үүнгүйгээр нийгмийн бүтээн үйлдвэрлэх ажиллагаанд амжилт олж болохгүй, ингэхлээр нийгмийн үйлдвэрлэл байж болохгүй юм.” хэмээн “хэл бол хүмүүсийн бие биетэйгээ харилцан саналаа солилцож, харилцан учраа мэдэлцэж байдаг зэвсэг хэрэглүүр мөн.” (Лувсанвандан, Ш, 1951:1) болох талаас нь тайлбарлан бичжээ.

Б.Дэмчигдоржийн өөр нэг судалгааны ажил бол түүний бичсэн диссертациуд юм. Тэр бээр монгол хэлний хоёр ч сэдвээр диссертац бичиж байсан боловч хамгаалаагүй байна. Чухам яагаад хамгаалаагүй талаар мэдээлэл олдсонгүй.

Хоёр диссертацын эхнийх нь Монгол хэлний хоршоо үгийн сэдэв байна. Энэ нь 1970 онд бичиж эхэлсэн “Халх монгол хэлний үг хорших ёс” хэмээх ажил бөгөөд эл ажлаа Оршил, үг хорших ёсыг ангилахуй нь, идэвхтэй язгуур, үндэс (тийн ялгалаар ялгаллагдах) үгс хорших ёс, тэмдэг нэр хоршихуй нь, тооны нэр хоршихуй нь, үйл үг хоршихуй нь, цагт нэр хоршихуй нь, төлөөний нэр хоршихуй нь, сул үг хоршихуй нь, үг хоршихуйд үгүйсгэх дайвар үг-ийн үүрэг, ерөнхий дүгнэлт” гэсэн төлөвлөгөөр 50 шахам хуудас бичиж байжээ.

Энэхүү ажлаа бичиж байхдаа тухайн үеийн Гадаад Явдлын Яамны сайд Л.Тойвд өргөдөл өргөсөн бөгөөд тус өргөдөлдөө “Миний бие өнгөрсөн намар ШУА-ийн аспирантурын комиссоор орж, эрдмийн зэрэг горилох журмаар, эрдэм шинжилгээний ажил хийх тухайн зөвшөөрлийг олж авсны үндсэн дээр одоо “Халх монгол хэлний үг харших ёс (хорших ёс Ж.Б.)” гэдэг сэдвээр ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү сэдвээ ШУА-ийн Хэл утга зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн энэ 2 сард болох хурлаар оруулж албан ёсоор батлуулах болсон тул, миний сэдвээ батлуулах гэсэн хүсэлтийг дэмжин зөвшөөрсөн коллегийн зөвшөөрөл гаргаж өхийг гүнээ хүсье” референт Б.Дэмчигдорж, 1970-2-5 гэсэн өргөдлийг бичсэний хариуд “Улсад 27 жил, түүнээс Гадаад Явдлын Яам болон түүний системийн байгууллагад 16 жил идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа ахмад ажилтан референт н.Дэмчигдорж нь өөрийн үүрэгт ажлаас гадуур “Халх монгол хэлний үг хорших ёс” гэсэн сэдэв дээр эрдмийн зэрэг горилох журмаар эрдэм шинжилгээний ажил хийж эхэлсэн тухайгаа тус Яамны удирдлагад танилцуулж, улмаар ШУА-ийн хэл утга зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр уг сэдвээ оруулан батлуулахыг хүсэж буй н.Дэмчигдоржийн хүсэлтийг дэмжиж байгаагаа ШУА-ийн Хэл утга зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлд мэдэгдье. Коллегийн дарга Л.Тойв, коллегийн нарийн бичгийн дарга С.Доржпүрэв, 1970-02-17-ны өдөр” гэсэн хариу бичиг өгчээ. Энэ бичгээс үзвэл эл сэдвээр ажиллахаар Хэл зохиолын хүрээлэнд санал гаргасан бөгөөд тус хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөс дэмжээгүй байж магад.

Харин нөгөөх нь мөн 1971 онд бичиж бэлэн болгосон “Орчин цагийн халх монгол хэлний дүрслэх үгийн тухай” диссертацийн ажил байна. Энэ диссертацийг Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн эсэх талаар баримт хараахан гарч ирээгүй байна.

1970 онд “Монгол хэлний хорших ёс”-оор төлөвлөгөө гаргаж 50 шахам хуудас бичсэн боловч 1971 он гэхэд “Монгол хэлний дүрслэх үг”-ийн асуудлаар диссертаци биччихсэн байгаа нь өмнөх ажлаа шууд орхиод дараагийн ажилд шуурхайлан орсныг харуулж байна.

Монгол хэлний дүрслэх үг бол маш сонирхолтой сэдэв бөгөөд монгол хэл судлаачид дүрслэх үгийг бие даасан ай (2007:23) болгон үзэж авиа дуурайх үг, дүрс дуурайх үгс гэж хоёр үндсэн хэсэгт хувааж судалсаар иржээ.

Тэр бээр энэ ажлаа бичихдээ нарийн төлөвлөгөө гаргаж бичиж байжээ. Тэр бээр энэ төлөвлөгөөндөө бичихдээ, “Халх монгол хэлний үгсийн сан дахь дүрслэх үгсийг судалж доорх зүйлсийг тогтоон баримтаар нотлох. Үүнд, Дүрслэх үгс гэж ямар үгсийг хэлэх, дүрслэх үгийн бүтэц, дүрслэх үгсийн өвөрмөц онцлогууд юу болох гэх мэтээр төлөвлөж халх монгол хэлний үгсийн санд ямар шинж чанартай дүрслэх үгс байгааг тус бүрийн онцлогоор нь ангилан тогтоох, дүрслэх үгсийн авиан зүйн ба үг зүйн бүтэц, өгүүлбэр зүй, найруулга зүйд гүйцэтгэх үүргүүдийг тодорхойлох, дүрслэх үг бол биеэ даасан ай үг болохыг нотлон тогтоох зэрэгт гол зорилт оршино.” гэжээ.

Мөн БНМАУ-ын Гадаад явдлын яамны референт Б.Дэмчигдоржоос “Орчин цагийн халх монгол хэлний дүрслэх үгийн тухай” 1972 онд бичиж байсан эрдэм шинжилгээний ажил бичих төлөвлөгөөндөө “... монгол хэлний дүрслэх үгийн

гүйцэтгэх үүрэг ба мөн чанарыг судлахдаа, 1-рт, орчин цагийн халх монгол хэлний дүрслэх үгсийг үгийн бүтцийг нарийвчлан судлах, 2-рт дүрслэх үгсийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, 3-рт дүрслэх үгс, дуу чимээний дуурайн үгсийн адил төстэй талыг нотлох, 4-рт дүрслэх үгс нь хэл зүйн биеэ даасан ай үгс болохыг баримтаар нотлох, 5-рт дүрслэх үгс нь үг зүй, өгүүлбэр зүй болон утга зүй, найруулга зүйн үүднээс ямар ач холбогдолтой болохыг нотлох, 6-рт Дүрслэх үгийн зөв бичих зүйн зарчмыг тодруулах зэргээр дүрслэх үгсийн үндсэн онцлог, өвөрмөц талуудыг эх хэлнийхээ хэрэглээнд байгаа дүрслэх үгийн жишээнүүд дээр үндэслэн тулгаварлан зохих тайлбар нотолгоог гарган дүгнэж бичнэ. (гар бичмэл:1972)” гэжээ.

Түүний энэхүү бичсэн диссертацийн дөрвөн эх материал манай хүрээлэнгийн “Эх хэл бичгийн сан хөмрөг, лаборатори”-д хадгалагдаж байгаа бөгөөд 1971 оны буюу анхны эх нь нийт А4-ийн 282 тал машиндсан хуудас болж байна. Мөн 1972 он гэсэн хоёр дахь диссертаци нь удиртгал 1-27 тал, нэгдүгээр бүлэг 27-167 тал, хоёрдугаар бүлэг 168-239 дэх талтай нийт А4-ийн 239 тал бүтээл байна. Гурав дахь диссертаци бүхий хавтаст 1973 он гэсэн байх бөгөөд энэ нь гараар дугаарласан А4 -ийн 192 тал ажээ. Харин дөрөв дэх хавтаст байгаа диссертаци нь 1985 он гэснээ дарсан байх бөгөөд энэ нь 1-р бүлэг 60 тал, хоёрдугаар бүлэг 73 тал, гуравдугаар бүлэг 74 тал бүгд 207 тал бүхий ажээ.

Тэр бээр энэхүү нэг сэдэвт бүтээлээ, дуурайн үгс гэдэг нэр томъёог ашигласан бөгөөд “Удиртгал, нэг, хоёрдугаар бүлэг” гэсэн бүтэцтэй бичжээ. Удиртгал бүлэгтээ дэлхийн хэлнүүдийн авиа дуурайх үгсийн нийтлэг ба онцлог талыг дурдсан бол нэгдүгээр бүлэгтээ, халх монгол хэлний дүрслэх үгийн тухай, дүрслэх дууриан үгс ба түүний язгуур бүтэвэрүүд, халх хэлний дүрслэх үгийн амьд ба мөхсөн холимог язгуурууд, дүрслэх дуурайн үгсийн амьд язгуур, дүрслэх дуурайн үйл үгс, дүрслэх дуурайн үгсийн өвөрмөц хувирал, дүрслэх цэвэр үйл үгс, Дүрслэх угтваршил үгс, дүрслэх угтваршил үгсийг ерөнхий утгаар нь ангилахуй, дүрслэх угтваршил үгс тус бүрийн утгын ялгараа зэргийг, хоёрдугаар бүлэгтээ, халх монгол хэлний дуу чимээний дуурайн үгс, халх монгол хэлний үүсмэл ба үүсмэл биш дуу чимээний дуурайн үгс, нийлмэл аргаар бүтсэн дуу чимээний дуурайн үгс ба дуу чимээний үйл үг үүсэхүй нь, дуу чимээний дуурайн үгсийг давтан хэрэглэхийн учир, дуу чимээний дуурайн үгсээс хоршоо үг бүтэх нь гэх мэтээр бүлэглэн хувааж авч үзжээ.

Ийнхүү монгол хэлний дүрслэх үгийг алтай түрэг язгуурын хэлнүүдийн дүрслэх үгтэй харгуулан үзэж, монгол хэлний дүрслэх үгийн онцлогийг батлан харуулах утга зохиолын хэлний хангалттай баримт дээр тулгуурласан 240 хуудас бүхий нэг сэдэвт зохиолыг бүрэн бичиж дуусгасан нь өнөөдөр ч гэсэн үнээ цэнээ алдаагүй бөгөөд уг сэдвийн нэгэн сэдэвт ажлын хүрээнд нэгэнт бичиж гаргасан учир цаашид нэн даруй хэвлүүлж судалгааны эргэлтэд оруулах нь чухал ач холбогдолтой болох нь түүний манай сан хөмрөгт хадгалагдаж байгаа энэхүү нэгэн сэдэвт зохиолуудын хувилбаруудаас тодорхой харагдаж байна.

Дүгнэлт

Энэ бүхнээс дүгнэн үзвэл жар, далаад оны үеэс Монгол улсын Боловсрол, гэгээрлийн яаманд ажиллаж монгол хэлний заах арга, сургалтын чиглэлээр захиргааны ажил хийхийн зэрэгцээ тухайн үеийн эрдэм шинжилгээ, заах аргын сэтгүүлүүдэд сургалт, заах арга, судалгааны дорвитой өгүүллүүд хэвлүүлж, мөн орчин цагийн монгол хэл шинжлэл түүний дотор үгийн сан, утга зүйн онцгой нэгэн чухал бөгөөд сонирхолтой сэдэв болох дүрслэх үгийн тухай асуудлыг сонгон авч нэгэн сэдэвт бүтээл бичиж бүрэн дуусгасан нь Б.Дэмчигдорж монгол хэл шинжлэлд хувь нэмрээ оруулсан судлаач мөн болохыг бэлхнээ харуулж байна гэж дүгнэн үзэж болно. Түүний энэхүү диссертацийг ойрын хугацаанд хэвлүүлж эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах нь чухал байна.

Ном зүй

- Базаррагчаа, М. (2007) *Дүрслэх үгс бие даасан ай болох нь*” [МУИС-ийн МХСС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, ХХҮП (285), 23-41 дэх талд]
- Базаррагчаа, М. (2017) *Монгол хэлний бүтээвэр судлал* Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган, Уб.,
- Бэшэ, Л. (1966/1967), *Монгол хэлний үйл үгийн угтварын тухай*, Монголын судлал, 6-р боть, Уб., 96 дахь талд.
- Дэмчигдорж, Б. (1952) *Чойбалсан ба Монголын утга зохиол*, Цог сэтгүүл, №1, 15-22 дахь талд.
- Дэмчигдорж, Б. (1978) *Орчин цагийн халх монгол хэлний дүрслэх үгийн тухай*, (машины бичмэл диссертаци 127 тал.) [ШУА-ийн ХЗХ-ийн эх хэл бичгийн сан хөмрөг, лаборатори]
- Дэмчигдорж, Б. (2023) *А.П.Чехов, Ёгт өгүүллэгүүд*, Монсудар, Уб.,
- Лувсанвандан, Ш., Дэмчигдорж, Б. (2010) *Монгол хэлний зүй*, Уб.,
- Ш.Лувсанвандан, Б.Дэмчигдорж, (1951) “Монгол хэлний зүй нэгдүгээр дэвтэр, Авиа ба үгийн зүй, Уб., 1 дэх тал. [Шадавын Лувсанвандан, Бүтээлийн чуулган, II боть, Уб., 2010]
- Хувийн (1983) *Б.Дэмчигдоржийн гурван үеийн намтар (гар бичмэл)*
- Хамтын (1953) *Их оросын хэлийг эрхэмлэж судлагтун*. Уб., Улсын хэвлэл
- Цэвэгжав, Б., Дэмчигдорж, Б. (1951) *Багш нарын лавлах бичиг (3 дугаар дэвтэр)* Гэгээрлийн яамны хэвлэл, Уб.,

Abstract

In the history of Mongolian linguistics, there are many people who have studied the Mongolian language and linguistics, but some people are not well known by the public. One of them is Demchigdorj Baljirtündev, who was in charge of the Mongolian language affair at the Ministry of Enlightenment (Education) of Mongolia in 1960 and was also researching the modern Mongolian language. Heritage and documentary materials related to the life and research work of this person have recently been registered in the fund of our institute, and based on those materials, this article is being written in order to clarify and inform about the research done by this person on the Mongolian language.